# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 24 (453)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай*
- *Хэлэлцээрт нэгдэн орсныг соёрхон батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Дүрэм батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Дамдинсүрэнгийн Цэвээндоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2006 оны зургадугаар сарын 28 №24 (453)


## Гарчиг


### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 321. | Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай | | 682 |
| 322. | Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 682 |
| 323. | Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 684 |
| 324. | Хэлэлцээрт нэгдэн орсныг соёрхон батлах тухай | | 684 |
| 325. | Протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай | | 684 |
| 326. | Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай | | 684 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 327. | Дүрэм батлах тухай | Дугаар 45 | 684 |
| 328. | Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг буцаах тухай | Дугаар 48 | 687 |
| 329. | "Авилгалаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслийг буцаах тухай | Дугаар 50 | 687 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 330. | Дамдинсүрэнгийн Цэвээндоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 126 | 688 |
| 331. | Ломбоцэрэнгийн Гүржавт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 127 | 688 |
| 332. | Найдангийн Намхайд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 128 | 688 |
| 333. | Бэгзийн Доржид Монгол Улсын гавьяат агроном цол хүртээх тухай | Дугаар 129 | 688 |
| 334. | Дамбын Цэмбэлд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 130 | 689 |
| 335. | Сономын Лочинд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 131 | 689 |
| 336. | Дожоогийн Цэдэвт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 132 | 689 |
| 337. | Далантайн Мичкад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 133 | 689 |
| 338. | Бадрахын Сурмаажавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 134 | 690 |
| 339. | Ойдовсамбуугийн Дашдэндэвт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 135 | 690 |
| 340. | Нягметын Есейд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 136 | 690 |
| 341. | Ганболдын Дэмбэрэлсайханд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай | Дугаар 137 | 690 |
| 342. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 138 | 691 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 343. | Журам батлах тухай | Дугаар 115 | 694 |
| 344. | Барилгын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 119 | 697 |
| 345. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 120 | 698 |
| 346. | Хамгаалалтын бүс тогтоох тухай | Дугаар 123 | 698 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

### ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд 2006 оны 3 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 7–ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 6, 8 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 14, 15, 16 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэг тус тус нэмсугай:

1/ **8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг**:

"3. Зэвсэгт хүчний цэргийн цол, ялгах тэмдэг, дүрэмт хувцсыг бусад байгууллага, иргэн хэрэглэх, тэдгээрийн загварыг ашиглахыг хориглоно."

2/ **12 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг**:

"6. Захиргааны санаачлагаар буюу өөрийн хүсэлтээр алслагдсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшаар ажиллаж байгаа хоёрдугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн иргэнийг байлдагч, түрүүчийн албыг хаах насны дээд хязгаарт хүрмэгц цэргийн дүйцүүлэх албыг хаасанд тооцно. Алслагдсанд тооцох сумдын нэрсийн жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар тогтооно."

7. Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт заасан үндэслэлээр хугацаат цэргийн ээлжит татлагаас түр чөлөөлөгдсөн иргэнд 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг хамаарахгүй."

3/ **18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт**:

"4/ гэрээт цэргийн алба хаасан байлдагч, түрүүч."

4/ **28 дугаар зүйлийн 14, 15,16 дахь хэсэг**:

"14. Шаардлагатай тохиолдолд Нэгдсэн үндэсний байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдарыг нөхөн сэргээх, сувилах зардлыг төр хариуцах бөгөөд энэхүү зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар тогтооно.

15. Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан иргэн төрийн болон төрийн бус өмчийн магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид элсэн суралцсан тохиолдолд төрийн сангийн зээлд эхний ээлжинд хамруулах ба энэхүү зээлд хамруулах журмыг Засгийн газар тогтооно.

16. Алслагдсан цэргийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор тухайн гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоно. Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар тогтоох бөгөөд тусламжид шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгана."

5/ **32 дугаар зүйлийн 3 дахь хэсэг**;

"3. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчсөн хуулийн этгээдийн хууль бусаар олсон орлого буюу эд хөрөнгийг хураах, иргэн, албан тушаалтныг 10000-60000 төгрөгөөр, байгууллагыг 80000-250000 төгрөгөөр эрх бүхий улсын байцаагч тус тус торгоно."

**2 дугаар зүйл.** Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 13 дугаар зүйлийн 2, 17 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн "батлан хамгаалах" гэсний дараа "болон хууль зүй, дотоод хэргийн" гэж; 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "олгох" гэсний дараа ", хэрэглэх, буурүүлах, хураан авах" гэж; 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "ёс зүйн" гэсний дараа "болон энэ хуульд заасан бусад" гэж; 31 дүгээр зүйлийн "Дайчилгаагаар" гэсний өмнө

"Бүх нийтийн болон хэсэгчилсэн" гэж; 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "аймаг нийслэлийн Засаг дарга" гэсний дараа ", цэргийн штабын дарга" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэр, 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ **6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг**:

"1. Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын иргэнийг оршин суугаа нутаг дэвсгэрээс нь үл хамааран цэргийн жинхэнэ албанд татах, цэргийн жинхэнэ болон гэрээт цэргийн албыг сайн дураар хаалгах журмаар нөхөн хангана."

2/ **9 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг**:

"6. Цэргийн албанд татагдагчийг аймаг, нийслэлийн цэрэг татлагын байр хүргэхэд шаардлагатай тээвэр, хүнс, байрны зардлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, цэргийн албанд тэнцсэн иргэнийг цэрэг татлагын байран дээр түр байрлуулах, хооллох, цэрэг татлагын байрнаас цэргийн анги хүргэх зардлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб тус тус хариуцна.

7. Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэнийг шаардлага гарсан тохиолдолд цэргийн жинхэнэ албанд татах ажлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна."

3/ **12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг**:

"2. Цэргийн албанд эрүүл мэндээр тэнцээгүй иргэн, түүнчлэн эрүүл мэндээр тэнцэж, цэргийн алба хаах хүсэлт гаргасан хэдий ч хугацаат цэргийн албанд татах иргэдийн хяналтын тоонд багтаагүй иргэнийг хугацаат цэргийн албанд татахаас тухайн жилд түр чөлөөлнө."

4/ **14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэр**:

"Хугацаат цэргийн алба хаах хугацаа 12 сар, гэрээт цэргийн алба хаах анхны хугацаа 24 сар байх бөгөөд гэрээний хугацааг цаашид 31 нас хүртэл үргэлжлүүлэн сунгаж болно."

5/ **16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг**:

"4. Цэргийн жинхэнэ албанаас халагдсан байлдагч, түрүүчийн тээвэр, хоол, хүнс, байрны зардлыг аймаг, нийслэл хүртэл Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, сум, хорооны төв хүртэл аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар тус тус хариуцна.

Харин хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн болон орон нутгийн чөлөөгөөр яваа байлдагч, түрүүчийн орон нутагтаа очих, буцах зардлыг цэргийн анги, байгууллага олгоно."

6/ **20 дугаар зүйл**:

"Цэргийн бэлтгэл албанд дээд, ахлах офицер 60 нас , дунд офицер, ахлагч 55 нас , эмэгтэй офицер, ахлагч болон байлдагч, түрүүч 50 нас хүртэл байж болно."

**4 дүгээр зүйл.** Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Зэвсэгт хүчин, бусад" гэснийг "Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд" гэж; 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Зэвсэгт хүчин, бусад цэргийн", 26 дугаар зүйлийн 1 дэх заалтын "Зэвсэгт хүчин, бусад" гэснийг "Зэвсэгт хүчний" гэж; 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн дугаарыг "8" гэж; мөн хэсгийн "Мөнгөн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлж, батлан хамгаалах зорилгод зарцуулна." гэснийг "Мөнгөн төлбөрийн орлогын 50 хүртэлх хувийг орон нутгийн төсөвт, үлдсэнийг улсын төсөвт төвлөрүүлэн батлан хамгаалах зорилгод зарцуулна." гэж; 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "байлдагч, түрүүчийн албыг 27 нас хүртэл" гэснийг "байлдагч, түрүүчийн албыг: -хугацаат цэрэг 27 нас хүртэл; -гэрээт цэрэг 31 нас хүртэл" гэж; 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб" гэж; 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хошууч генерал, дэслэгч генерал, хурандаа генерал, маршал" гэснийг "бригадын генерал, хошууч генерал, дэслэгч генерал, генерал " гэж; мөн зүйлийн 4 дэх хэсгийн "бүртгэлээр" гэснийг "бэлтгэлээр" гэж; 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "иргэний паспортод" гэснийг "цэргийн үүрэгтний үнэмлэхэд" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ", татлагын байранд бүртгүүлсэн" гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Захиргааны хариуцлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд "11/ хуульд тусгайлан заасан тохиолдолд аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга." гэсэн заалт нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

### ХЭЛЭЛЦЭЭРТ НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2004 онд Бухарест хотноо хуралдсан Дэлхийн шуудан холбооны Бүрэн Эрхт төлөөлөгчдийн ээлжит их хурлаар хэлэлцэж баталсан "Шуудангийн санхүүгийн үйлчилгээний хэлэлцээр"-т Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

### ПРОТОКОЛД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2004 онд Бухарест хотноо хуралдсан Дэлхийн шуудан холбооны Бүрэн Эрхт төлөөлөгчдийн ээлжит их хурлаар хэлэлцэж баталсан "Дэлхийн шуудан холбооны дүрмийн долдугаар нэмэлт протокол"-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

### КОНВЕНЦИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Лондон хотноо баталсан "Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол"-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

### Дүрэм батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолын хавсралт

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДҮРЭМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрмээр Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/, түүний ажлын албаны үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах нэгдсэн бодлого боловсруулж, банк бус санхүүгийн, даатгалын, хоршооны хадгаламж зээлийн үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээл, хуульд заасан санхүүгийн бусад харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

1.3.Хороо тогтоосон журмаар үйлдсэн Монгол Улсын төрийн сүлд бүхий тамга, түүнчлэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.4.Хороо, түүний ажлын алба нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нутгийн захиргааны болон бусад байгууллагатай хамтран ажиллана.

### ХОЁР. Хорооны бүрэн эрх

2.1.Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь үндсэн зорилтуудыг хангаж биелүүлнэ:

2.1.1. санхүүгийн зах зээлд өрсөлдөөн бий болгох;

2.1.2. хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, даатгуулагч, хадгаламж эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

2.1.3. санхүүгийн зах зээлд итгэлцлийг бий болгох;

2.1.4. санхүүгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн сахилгыг дээшлүүлэх;

2.1.5. олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох;

2.1.6. иргэд, олон нийт, санхүүгийн зах зээлд оролцогчдыг бодит мэдээллээр хангах.

2.2.Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд дараахь эрх эдэлнэ:

2.2.1. санхүүгийн зах зээлийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

2.2.2. санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хувьцаат компани, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, хадгаламж зээлийн хоршоо, тэдгээрийн хөрөнгө оруулагч, даатгуулагч, хадгаламж эзэмшигч, үйлчлүүлэгч болон холбогдох бусад иргэн, хуулийн этгээдээс тэдгээрийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны тайлан, тодорхойлолт, мэдээ авах;

2.2.3. энэ журмын 2.2.2-т заасан оролцогчдын үйл ажиллагааны талаарх шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг бусад байгууллага, иргэдээс гаргуулан авах;

2.2.4. Хорооны орон тооны бус гишүүд болон хянан шалгагчдад олгох урамшууллын хэмжээг тогтоох, түүнийг олгох журам батлах;

2.2.5. хуульд заасан зохицуулалт, хяналт шалгалтын үйл ажиллагаандаа холбогдох мэргэжилтэн, аудитор, мэргэжлийн байгууллагыг татан оролцуулах;

2.2.6. энэ журмын 2.2.2-т заасан оролцогч, түүний албан тушаалтанд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хариуцлага хүлээлгэх;

2.2.7. энэ журмын 2.2.2-т заасан оролцогчид хуульд заасан эрх хэмжээний хүрээнд албан шаардлага өгөх, түүнийг биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг хуульд заасан шийдвэр гаргах;

2.2.8. энэ журмын 2.2.2-т заасан оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хянан шалгахтай холбоотой хуульд заасан бусад үйл ажиллагаа явуулах;

2.2.9. Хорооны үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх санхүүгийн болон хүний нөөц, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.2.10. хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа.

2.3.Хороо нь зохицуулалт, хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл энэ журмын 2.2.2-т заасан оролцогчтой нэгдмэл ашиг сонирхолтой буюу түүний хараат болон охин компани, түүнчлэн урьд нь зохицуулалтын үйлчилгээний хүрээнд хамаарч байсан оролцогчдын үйл ажиллагааг шалгах эрхтэй.

### ГУРАВ. Хорооны дарга, гишүүдийн чиг үүрэг

3.1.Хорооны дарга Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд дараахь эрх эдэлнэ:

3.1.1.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.1.2.Хороо, түүний ажлын албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3.Хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

3.1.4.Хорооны үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, биелэлтэд нь хяналт тавих;

3.1.5. Хорооны ажлын албаны даргыг томилох;

3.1.6. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү дүрэмд заасан Хорооны зорилго, зорилтыг бүхэлд нь хангах асуудлыг биечлэн хариуцаж зохион байгуулах;

3.1.7. санхүүгийн зах зээлийн байдлын талаар Улсын Их Хурал, холбогдох Байнгын хороог мэдээллээр хангах, Төв банк /Монголбанк/, Засгийн газарт санамж бичигт заасан хугацаанд мэдээлэл өгөх.

3.2.Хорооны дарга хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд тушаал гаргах эрхтэй.

3.3.Хорооны орон тооны гишүүн нь Хорооны дэд даргын статустай байна.

3.4. Хорооны гишүүд дор дурдсан эрх, үүрэгтэй:

3.4.1. Хорооны ажлын албаны дарга болон газар, нэгжийн удирдлагад үүрэг, даалгавар өгөх, гүйцэтгэлд хяналт тавих;

3.4.2. Хорооны хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх санал оруулах;

3.4.3. Хорооны хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан нэмэлт баримт бичиг шаардах буюу гаргаж өгөх, өөрийн зарчмын зөрүүтэй саналыг хуралдааны тэмдэглэлд тусгуулах,

3.5.Хорооны дарга улсын ерөнхий байцаагчийн, гишүүд улсын ахлах байцаагчийн эрхтэй байна.

**ДӨРӨВ. Хорооны зохион байгуулалт**

4.1.Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь түүний хуралдаан байна.

4.2.Хороо нь зохицуулалтын үйлчилгээний хүрээний тодорхой салбарын үйл ажиллагаа, чиг хандлагын талаар зөвлөлдөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгч, үйлчлүүлэгч, мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор байгуулж болно.

4.3.Хороо жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнана.

4.4.Ажлын алба нь Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах бөгөөд түүний бүтэц, орон тоог Хороо тогтооно.

4.5.Ажлын албаны дарга нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18.3-т зааснаас гадна дор дурдсан эрх, үүрэгтэй:

4.5.1. Хорооны ерөнхий менежерийн хувьд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

4.5.2. Хорооны төсвийг захиран зарцуулах;

4.5.3. ажлын албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;

4.5.4. ажлын албаны ажилтнуудыг хуульд заасан үндэслэл журмын дагуу ажилд томилох, чөлөөлөх, тэдгээрт цалин, урамшуулал олгох шийдвэр гаргах;

4.5.5. Хорооны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих;

4.5.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

4.6.Ажлын алба нь дараахь чиг үүрэгтэй байна:

4.6.1. санхүүгийн тогтвортой байдлыг хангах, энэ журмын 2.2.2-т заасан оролцогчдын төлбөрийн чадварыг бэхжүүлэх талаар Хорооноос тогтоосон шаардлагыг мөрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон заавар, зөвлөмжийн төсөл боловсруулж Хороонд оруулах;

4.6.2. энэ журмын 2.2.2-т заасан оролцогчийн нягтлан бодох бүртгэл, тайлангийн маягт, тайлагнах журмын төслийг боловсруулж хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.6.3. хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, даатгуулагч, хадгаламж эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авахад нь Хороонд дэмжлэг үзүүлэх;

4.6.4. санхүүгийн зах зээлийн хөгжлийн талаархи мэдээлэл судалгааны сан бүрдүүлэх;

4.6.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд мониторинг хийх;

4.6.6. Хорооноос олгосон зөвшөөрөл, эрх болон тэдгээрт оруулсан өөрчлөлтийг бүртгэх, үнэт цаасны нэгдсэн бүртгэл хөтлөх;

4.6.7. хууль тогтоомж, журам, заавар, стандарт, арга зүйн материал зөвлөмжийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

4.6.8. олон нийтийг Хорооны болон энэ журмын 2.2.2-т заасан оролцогчдын үйл

ажиллагааны талаарх мэдээллээр хангах, лавлагаа өгөх;

4.6.9. Хорооноос энэ журмын 2.2.2-т заасан оролцогчид хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавихад болон Хороо, Хяналтын зөвлөл, түүний гишүүдэд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь техник, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

4.6.10. Хорооноос санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хөгжлийн асуудлаар гадаад орон болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.6.11. Хорооноос энэ журмын 2.2.2-т заасан оролцогчдын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх.

**ТАВ. Хорооны эд хөрөнгө, санхүүжилт, нягтлан бодох бүртгэл**

5.1.Хорооны хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө нь төрийн өмч байна.

5.2.Хорооны санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.2.1. улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

5.2.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс;

5.2.3. хуулийн дагуу явуулсан үйл ажиллагаанаас олох бусад орлого.

5.3.Хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоохдоо зах зээлийн хөгжлийг дэмжих, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, энэ журмын 2.2.2-т заасан оролцогчдын үйл ажиллагааны төрөл, санхүүгийн чадавхид нийцүүлэх зарчмыг баримтална.

5.4.Хороо өөрийн орлогыг аажмаар нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийг бууруулах зарчмыг баримтална.

5.5.Хороо нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн жилийн тайлангаа аудитын байгууллагаар баталгаажуулж, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 6 дугаар сарын 8-ны өдөр** **Дугаар 48** **Улаанбаатар хот**

**Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Л.Гүндалайгаас санаачилсан Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрүүл мэндийн даатгалын хүрээнд гарч байгаа шинэ харилцааг бүрэн зохицуулаагүй, мөн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог үзэл баримтлалын хувьд өөрчлөх асуудлыг тодорхой тооцоо, судалгааны үндсэн дээр иж бүрнээр авч үзээгүй, уг асуудлаар Засгийн газрын танхимын байр суурь дотроо зөрчилтэй, нэгдмэл ойлголтод хүрээгүй байх тул эдгээр хуулиудын төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

2.Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хуулийн төсөлд тусган дахин боловсруулж Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийг 2006 оны 6 дугаар сарын 20-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2006 оны 6 дугаар сарын 9-ний өдөр** **Дугаар 50** **Улаанбаатар хот**

**"Авилгалаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслийг буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 17.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газраас 2006 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Авилгалаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын төсөлд тусгагдсан "Авилгалын эсрэг амлалт" өгөх асуудал нь Төрийн албаны хуулиар нэгэнт зохицуулагдсан байх тул төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 126** **Улаанбаатар хот**

**Дамдинсүрэнгийн Цэвээндоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Шинжлэх ухааны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж археологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, эртний нүүдэлчдийн түүх соёлын дурсгалыг судлах, хадгалж хамгаалах, эрдэмтэн судлаачдын залуу үеийг сургаж бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал Дамдинсүрэнгийн Цэвээндоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 127** **Улаанбаатар хот**

**Ломбоцэрэнгийн Гүржавт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Боловсролын салбарт он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Монголын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх онол, Монголын зах зээлийн хөгжлийн загвар, өрсөлдөх чадвар зэрэг эрдэм шинжилгээний цуврал бүтээлүүд туурвиж, эдийн засаг, удирдлагын чиглэлээр үндэсний дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУТИС-ийн Компьютер менежментийн сургуулийн зөвлөх, профессор Ломбоцэрэнгийн Гүржавт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 128** **Улаанбаатар хот**

**Найдангийн Намхайд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Эрчим хүчний салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем боловсруулж хэрэгжүүлэх, төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг хангах, нийслэл хотын цахилгаан хангамжийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн зөвлөх инженер Найдангийн Намхайд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 129** **Улаанбаатар хот**

**Бэгзийн Доржид Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай**

Хөдөө аж ахуй, боловсрол, шинжлэх ухааны салбарт он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, газар тариалангийн чиглэлээр судалгаа шинжилгээний олон бүтээл туурвиж, хөдөө аж ахуйн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ХААИС-ийн Агробиологийн сургуулийн багш, доктор, профессор Бэгзийн Доржид Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 130** **Улаанбаатар хот**

**Дамбын Цэмбэлд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Хэвлэл-мэдээлэл, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж сэтгүүл зүй, эрдэм шинжилгээ, уран зохиолын шилдэг бүтээлүүд туурвиж, Монголын соёлыг хөгжүүлэх, гадаад оронд сурталчлах, залуу үеийнхний гоо зүйн боловсролыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч Дамбын Цэмбэлд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 131** **Улаанбаатар хот**

**Сономын Лочинд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Соёл, хэвлэл-мэдээлэл, шинжлэх ухааны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж Монголын уран зохиол судлалд бичвэр судлалын салбарыг бий болгон хөгжүүлж, олон арван түүхэн роман, тууж, өгүүллэг болон эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвиж, романы төрөл зүйлийг баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор, профессор Сономын Лочинд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 132** **Улаанбаатар хот**

**Дожоогийн Цэдэвт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, Монголын утга зохиолын хүүрнэл зохиол, яруу найраг, судлал шүүмжийн төрлийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Соёл урлагийн их сургуулийн захирал Дожоогийн Цэдэвт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 133** **Улаанбаатар хот**

**Далантайн Мичкад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Хүн амын ахуй үйлчилгээний нэр төрлийг олшруулж, ажлын байрыг нэмэгдүүлэн иргэдэд хөнгөн шуурхай үйлчилж, ахуй үйлчилгээний салбарт олон жил идэвх санаачилгатай ажиллаж байгааг нь үнэлж Нийслэлийн үйлдвэр, үйлчилгээний "ХӨМ" ХХК-ийн ерөнхий захирал Далантайн Мичкад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 134 | Улаанбаатар хот

**Бадрахын Сурмаажавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын үндэсний технологийг боловсруулж хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Орчлон" дунд сургуулийн сургалтын менежер, зөвлөх багш Бадрахын Сурмаажавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 135 | Улаанбаатар хот

**Ойдовсамбуугийн Дашдэндэвт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөө орон нутгийн эмнэлгийн байгууллагыг бэхжүүлж, эмчилгээний шинэ аргуудыг практикт нэвтрүүлэн, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Архангай аймгийн Батцэнгэл сумын сум дундын эмнэлгийн салбарын эрхлэгч, мэс заслын их эмч Ойдовсамбуугийн Дашдэндэвт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 136 | Улаанбаатар хот

**Ныгметын Есейд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээний шинэ аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлэн, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орон нутагт чадварлаг мэс заслын эмч нарыг сургаж бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын зөвлөх эмч Ныгметын Есейд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 137 | Улаанбаатар хот

**Ганболдын Дэмбэрэлсайханд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай**

Биеийн тамир, спортын салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, спортын өндөр амжилт гарган манай улсад волейболын спортыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын хорооны ахлах дасгалжуулагч Ганболдын Дэмбэрэлсайханд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 138 | Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, татвар, тээвэр, эрчим хүч, уул уурхай, хэвлэл мэдээлэл, цагдаа, онцгой байдал, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААНТУГИЙН ОДОНГООР:**

1. Лхамжавын Дүгэрсүрэн - Хараагүй иргэдийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн захирал
2. Дэмбэрэлийн Тэрбиш - Үйлдвэр, үйлчилгээний "Фармаци" ХХК-ийн захирал
3. Хинаятын Цоохүү - Шинжлэх ухаан технологийн сангийн захирал

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Лхамсүрэнгийн Адилбиш - Төв аймгийн Алтанбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
2. Дунхүүгийн Алтанхуяг - Завхан аймгийн Улиастай сум дахь барилгын материалын үйлдвэрлэлийн "Зуурмаг" ХХК-ийн засал чимэглэлчин
3. Занданбалын Алтанцэцэг - Нийслэлийн Ус суваг удирдах газрын эдийн засагч
4. Цэнзэнгийн Амарсайхан - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн багш
5. Дэмбэрэлдоржийн Аюуш - Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлгийн сэтгэцийн эмч
6. Зундуйн Баатаржав - "Монголпросцветмет" нэгдлийн харъяа Хэнтий аймаг дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн жолооч
7. Тогтохын Батаа - Увс аймгийн Наранбулаг сумын Алдар багийн Засаг дарга
8. Пандиагийн Батжаргал - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн малчин
9. Ядамын Батжаргал - Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн тасгийн дарга
10. Гончигийн Батнасан - "Газарчин" дээд сургуулийн багш
11. Жанцангийн Бархас - Өмнөговь аймгийн Сэврэй сумын Сайншанд багийн малчин
12. Хорхойн Басан - Увс аймгийн Малчин сумын "Улаанбулаг" хоршооны дарга
13. Намжилын Баярсайхан - "Эрчим хүчний барилга угсралт трест" ХК-ийн жолооч
14. Ваанжилын Буяндэлгэр - Дорнод аймгийн Халхгол сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
15. Дамбын Ганбат - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн
16. Хуушингийн Ганболд - Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
17. Чоймболын Гомбосүрэн - Увс аймгийн Өмнөговь сум дахь хөдөө аж ахуйн "Өмнөговь" хоршооны дарга
18. Батын Дагвадорж - Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хорооны иргэн, өндөр настан
19. Шагдарсүрэнгийн Дагвадорж - Монгол банкны Хяналт шалгалтын газарт ахлах хянан шалгагч
20. Тавхайн Дамдин - Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хорооны Иргэдийн Нэгдсэн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
21. Ламжавын Дамдинжав - Архангай аймгийн Цэцэрлэг сумын өндөр настан, худалдааны байгууллагын ахмад ажилтан
22. Цэрэнгийн Дамдинсүрэн - Засгийн газрын Цөмийн энергийн комиссын хариуцлагатай нарийн бичгийн дарга
23. Гэлэгдандарын Дамчаа - Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
24. Аниушкагийн Дашцэрэн - Увс аймгийн Хяргас сумын ЗДТГ-ын дарга
25. Бадраагийн Долгор - "НҮБ-ын ардчилсан парламент" төслийн зөвлөх
26. Дүгэрцэрэнгийн Долгор - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн багш
27. Доржпүрэвийн Долгоржав - Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн их эмч
28. Лхамсүрэнгийн Долгорсүрэн - ЭНЭШТ-ийн тасгийн эрхлэгч
29. Шархүүгийн Доржпалам - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн захирал
30. Осорбатын Доржсүрэн - Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ахмадын зөвлөлийн гишүүн
31. Жамьянгийн Дүгэрмаа - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2 дугаар сургуулийн сургалтын менежер
32. Лхасүрэнгийн Дэмбэрэл - Увс аймгийн Малчин сумын дунд сургуулийн багш
33. Сэрээтэрийн Дэмбэрэлдорж - Орхон аймгийн Аудитын газрын ерөнхий аудитор

34. Хядагийн Ёндон - Говь-Алтай аймгийн Чандмань сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
35. Чулуунбатын Ёндонноров - Өвөрхангай аймгийн Бүрд сумын ЗДТГ-ын Татварын улсын байцаагч
36. Жүрмэдийн Жадамба - Төв аймгийн Баянцагаан сумын 4 дүгээр багийн малчин
37. Чулууны Жанчивдорж - Булган аймгийн Рашаант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
38. Баатарын Жигжээ - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
39. Гаравсүрэнгийн Идэрмаа - "Улаанбаатар – Буян" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
40. Нүрзэдийн Лхагва - "Монгени" цогцолбор сургуулийн ерөнхий захирал
41. Лэгдэвийн Лхамаасүрэн - Нийслэлийн Ус суваг удирдах газрын ерөнхий санхүүч
42. Жамсрангийн Лхамсүрэн - Завхан аймгийн Улиастай сумын барилгын "Бэрсүм" ХХК-ийн засал чимэглэлчин
43. Цэрэнгийн Мишка - "Баянгол" эмнэлгийн зөвлөх эмч
44. Чулуунхүүгийн Намжилжав - Завхан аймгийн МАХН-ын хорооны нягтлан бодогч
45. Должидын Наран - Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ашиглалт хариуцсан инженер
46. Дамдинчогсомын Нацаг - Налайх дүүргийн 2 дугаар хорооны иргэн, өндөр настан
47. Шушмаагийн Нацагдорж - "Эрчим хүчний барилга угсралт трест" ХК-ийн мастер гагнуурчин
48. Бавганы Норовсамбуу - Монголын Үндэсний радиогийн Дархан-Уул аймаг дахь сурвалжлагч
49. Ядамын Нямдорж - Төв аймгийн Эрдэнэсант сумын 3 дугаар багийн малчин
50. Ядамсүрэнгийн Отгонжаргал - ХААН банкны Улаанбаатар төв салбарын захирал
51. Сыдыхын Өтебай - Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн улсын байцаагч
52. Буяагийн Пүрэвдорж - Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Хур чандмань" ХХК-ийн захирал
53. Балжирын Пэрэнлэй - Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
54. Гочоосүрэнгийн Сахьяабазар - Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны Хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
55. Ягамасын Сейт - Ховд аймгийн Ховд сумын хүн эмнэлгийн эрхлэгч
56. Ишдоржийн Содном - Нийслэлийн 4 дүгээр сургуулийн сантехникч
57. Намсрайн Сүрэнжав - Завхан аймгийн Тосонцэнгэл сумын барилга үйлдвэрлэлийн "Зост-Өргөө" ХХК-ийн захирал
58. Нямжавын Сүхдорж - "Зууны мэдээ" сонины Сэлэнгэ аймаг дахь орон нутгийн сурвалжлагч
59. Даваасамбуугийн Сэвжидхорлоо - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Далай ван" сургуулийн химийн багш
60. Дорждэрэмийн Сэлэнгэ - Завхан аймгийн Цагаанчулуут сумын дунд сургуулийн захирал
61. Янсангийн Сэнгэдорж - Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын орлогч
62. Пэрэнлэйн Төвсанаа - Баянгол дүүргийн МАХН-ын хорооны дэд дарга
63. Довчингийн Төгсбаяр - Налайх дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлийн дарга
64. Чимэддоржийн Төмөр - Завхан аймгийн Сонгино сумын Тариат багийн малчин
65. Гүндмаагийн Төмөрсүх - Өмнөговь аймгийн Ус цаг уурын орчны шинжилгээний газрын ерөнхий технологич
66. Жанцангийн Хоролсүрэн - Налайх дүүргийн Сод-Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн ерөнхий захирал
67. Ломойн Цогзолмаа - Дархан-Уул аймгийн Дархан сумын "Жигүүр" цогцолбор сургуулийн биологийн багш
68. Цоодолын Цэндсүрэн - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн багш
69. Банзайн Цэрэнлхам - "Эрчим хүчний барилга угсралт трест" ХК-ийн гагнуурчин
70. Санжаагийн Чангаа - Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
71. Жүгнээгийн Энхбаяр - Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ахлах мэргэжилтэн
72. Жамбалын Эрдэнэбаатар - Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хэлтсийн дарга
73. Сэр-Одын Эрдэнэчимэг - "Монгол охид" клубын захирал
74. Дoржваанчигийн Ягаан - Булган аймгийн Орхон сумын 4 дүгээр багийн малчин
75. Пунцагдашийн Ядамсүрэн - Ховд аймгийн Булган сумын МАХН-ын үүрийн нарийн бичгийн дарга
76. Цэрэнгийн Ядмаа - Увс аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч
77. Түвшингийн Янжив - Увс аймгийн Ховд сумын өндөр настан, ахмад тээвэрчин

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Дуламын Оюунчимэг - Замын цагдаагийн газрын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Жуудайн Алтангэрэл - Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн улсын байцаагч
2. Цэрэндоржийн Амаржаргал - Хөвсгөл аймгийн Рашаант сум дахь "Улаан-Од" ХХК-ийн захирал

3. Өвгөнхүүгийн Ариунтуяа - "Улаанбаатар зочид буудал" ХХК-ийн нярав

4. Рэнцэнгийн Аюуш - Булган аймгийн Гурванбулаг сумын 2 дугаар багийн Засаг дарга

5. Дашвандангийн Баатар - Ховд аймгийн Жаргалант сумын Хайрхан багийн Засаг дарга

6. Лувсанцэрэнгийн Баатар - Дархан-Уул аймгийн "ЛХА" телевизийн зураглаач-найруулагч

7. Дамбаасүрэнгийн Бадамсүрэн - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн бага ангийн багш

8. Цэрэндоржийн Батбаяр - Үндэсний аудитын газрын аудитор

9. Адилбишийн Батхишиг - Улаанбаатар хотын Гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэрт цахилгаанчин

10. Сэрсэнжавын Баяраа - Дархан-Уул аймгийн барилгын "Хаш цамхаг" ХХК-ийн мужаан

11. Жанлавын Баярхүү - Дорнод аймгийн үйлдвэрлэл, худалдааны "БД" ХХК-ийн зөвлөх инженер

12. Доржийн Бидэр - Архангай аймгийн Эрдэнэбулган сум дахь газар хөдлөлт бүртгэх "Цэцэрлэг" станцын эрхлэгч

13. Энэбишийн Болормаа - Архангай аймгийн Батцэнгэл сумын Нийгмийн даатгалын улсын байцаагч

14. Эрхэмийн Бямбасүрэн - Дархан-Уул аймаг дахь "Дарханы дулааны цахилгаан станц" ХК-ийн сэлбэгийн нярав

15. Доржийн Бужмаа - Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

16. Хорлоогийн Бурмаа - Орхон аймгийн Орхон цогцолбор сургуулийн бага ангийн багш

17. Сайнцогийн Вандандорж - Завхан аймгийн Сонгино сумын Тариат багийн малчин

18. Шаарийбуугийн Ганхуяг - Булган аймгийн Тэшиг сумын Далан багийн Засаг дарга

19. Дашцэрэнгийн Ганчимэг - Дорнод аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн

20. Чинсүрэнгийн Гончиг - Ховд аймгийн Дөргөн сумын "Бөлөөт нуур" мал эмнэлгийн малын бага эмч

21. Гэлэгсэнгийн Гэрэлцэцэг - ХААИС-ийн багш

22. Гомбосүрэнгийн Даваадэмбэрэл - Орхон аймаг дахь Гаалийн газрын гаалийн улсын байцаагч

23. Дарьсүрэнгийн Дагирмаа - Монгол кино нэгтгэлийн нүүр хувиргагч

24. Батдондогийн Далайсүрэн - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн багш

25. Бямбаагийн Дамдинбазар - Ховд аймгийн Алтай сумын Алтангадас багийн малчин

26. Баатарын Дарьхүү - Дархан-Уул аймгийн хүнсний "Дархан- Хүнс" ХК-ийн нягтлан бодогч

27. Цанлигийн Дашдондог - Архангай аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын голомт хяналтын бага эмч

28. Зундуйн Дунжидмаа - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн сургалтын технологич

29. Бадарчийн Дондогмаа - Төв аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

30. Ишбалын Дорж - Завхан аймгийн Улиастай сумын барилгын "Алтан харш" ХХК-ийн бригадын дарга

31. Галсангийн Доржрагчаа - Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн улсын байцаагч

32. Сосорын Дорлигсүрэн - Булган аймгийн Тэшиг сумын Засаг дарга

33. Бэгзжавын Дуламсүрэн - Хан-Уул дүүргийн Туул тосгоны 26 дугаар сургуулийн сургалтын менежер

34. Шаравсэнгийн Дүүриймаа - Орхон аймаг дахь Гаалийн газрын гаалийн улсын байцаагч

35. Дашзэвэгийн Ёндонцэрэн - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын өндөр настан, ахмад тээвэрчин

36. Баасанжавын Жаргалсайхан - "Эрдэнэ зам" ХХК-ийн дэд захирал

37. Уушийн Жимсээ - Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн газарзүйн багш

38. Санжмятавын Жигжээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 146 дугаар цэцэрлэгийн манаач

39. Төгөлдөрийн Ишханд - Хэнтий аймгийн Норовлин сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

40. Ёндонгийн Коля - Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар багийн Засаг дарга

41. Намнангийн Лхагвасүрэн - Сонгинохайрхан дүүргийн 15 дугаар хорооны иргэн, өндөр настан

42. Очирын Лхагважав - Дархан-Уул аймгийн Дархан сумын лицей 19 дүгээр сургуулийн багш

43. Сурахбаярын Лхамжав - Говь-Алтай аймгийн Халиун сумын хүн эмнэлгийн их эмч

44. Лхамхүүгийн Лувсанням - Завхан аймгийн НААҮ-ний "Амьд –Ус трейд" ХХК-ийн борлуулалтын менежер

45. Сэндомын Мөнхөө - Хөвсгөл аймгийн Тариалан сумын татварын улсын байцаагч

46. Чулууны Мөнхцоож - Ховд аймгийн Аудитын газрын ахлах аудиторч

47. Жанцангийн Наранцэцэг - Орхон аймгийн Баян-Өндөр цогцолбор сургуулийн багш

48. Сономын Наранцэцэг - Нийслэлийн 14 дүгээр сургуулийн сургалтын менежер

49. Авирын Нэргүй - Баянхонгор аймгийн 2 дугаар сургуулийн аж ахуйн эрхлэгч

50. Бадарчийн Ням-Очир - Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга

51. Санжаагийн Нямсүрэн - "Улаанбаатар зочид буудал" ХХК-ийн нярав

52. Чогсомын Нямсүрэн - Улсын Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлгийн инженер, тасгийн эрхлэгч

53. Баатарын Нямхүү - Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш

54. Эрдэмбилэгийн Одгэрэл - Оюуны өмчийн газрын мэргэжилтэн

55. Лувсангомбын Отгон - Орхон аймгийн Баян-Өндөр цогцолбор сургуулийн багш

56. Жигжидийн Оюумаа - Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын сум дундын хүн эмнэлгийн бага эмч

57. Аюушсүрэнгийн Оюун - Нийслэлийн 31 дүгээр сургуулийн багш

58. Гүрсэдийн Оюунчимэг - Булган аймгийн Дашинчилэн сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч

59. Баярын Пүрэвдорж - Дархан-Уул аймгийн Дархан сумын "Дархан-Ус суваг" ХК-ийн ерөнхий инженер

60. Намсрайжавын Пүрэвсүрэн - Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын түшмэл

61. Мижидийн Рэнцэндорж - IY цахилгаан станцын авто аж ахуйн дарга

62. Дашдоржийн Саран-Эрдэнэ - Төв аймгийн ЗДТГ-ын ахлах мэргэжилтэн

63. Цэдэвийн Сугармаа - Үндэсний аудитын газрын аудитор

64. Амгалангийн Сүхбаатар - Үндэсний аудитын газрын аудитор

65. Доржпаламын Сэрдсүрэн - Төв аймгийн Баян-Өнжүүл сум дахь ХААН банкны тооцооны төвийн эрхлэгч

66. Галиндарийн Сумъяа - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Хүнлэг говь" эмэгтэйчүүдийн эмнэлгийн захирал

67. Ухнаагийн Тамир - Харилцаа холбооны зохицуулах хорооны албаны дарга

68. Алгаагийн Толя - Увс аймгийн Тариалан сумын цэцэрлэгийн эрхлэгч

69. Наваанзундуйн Туяа - Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга

70. Чимэдбазарын Төмөрчөдөр - Төвийн бүсийн ЦДСК-ийн Налайх дэд станцийн монтёр

71. Баасаннандийгийн Уранчимэг - Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэгийн багш

72. Шөвхөөний Уртнасан - Орхон аймаг дахь Гаалийн газрын гаалийн жижүүр

73. Агваансодовын Халзанхүү - Нийслэлийн "Нөөц" компанийн менежер

74. Жамбаагийн Хишигсүрэн - Нийслэлийн 55 дугаар сургуулийн багш

75. Очирдагвын Хишигсүрэн - Нийслэлийн 14 дүгээр сургуулийн багш

76. Содовын Цагаан - Булган аймгийн ЗДТГ-ын түшмэл Булган аймгийн Гурванбулаг сумын 2 дугаар багийн Засаг дарга

77. Цагааны Цанашир - Орхон аймгийн Орон нутгийн өмчийн албаны мэргэжилтэн

78. Чанцалдуламын Цоодол - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Эрдмийн гэгээ" сургуулийн багш

79. Лхагвагийн Цэрэнбал - Хөвсгөл аймгийн Тариалан сумын өндөр настан, ахмад саальчин

80. Цэвэгжавын Цэрэнхүү - Үндэсний аудитын газрын аудитор

81. Гүндэгийн Цэцэгмаа - Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн нягтлан бодогч

82. Жамсранжавын Цэцэгмаа - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн бага ангийн багш

83. Хоролсүрэнгийн Цэцэгмаа - Завхан аймгийн Улиастай сумын 5 дугаар цэцэрлэгийн арга зүйч

84. Чимэддоржийн Цэцэгмаа - Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын дунд сургуулийн сургалтын менежер

85. Жамъянгийн Чимэдхорол - Орхон аймгийн Шуудан холбооны газрын ерөнхий нягтлан бодогч

86. Цэдэвийн Чинбат - Дорноговь аймгийн Хөвсгөл сумын хүн эмнэлгийн жолооч

87. Мишигдоржийн Чулуунбат - Төв аймгийн Заамар сумын Шижир алтны 8 жилийн сургуулийн захирал

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Баарангийн Бат-Очир - Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал унтраах 14 дүгээр ангийн салааны захирагч

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 5 дугаар сарын 24–ний өдөр** **Дугаар 115** **Улаанбаатар хот**

**Журам батлах тухай**

Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журам"-ыг 1 дүгээр, "Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөгжмийн том хэлбэрийн бүтээл, дүрслэх урлагийн шилдэг бүтээл болон ном

хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авахад зориулж тус бүр 50.0 (тавин) сая төгрөг, нийт 150.0 (нэг зуун тавин) сая төгрөгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлагийн шилдэг бүтээл худалдан авах тухай" Засгийн газрын 1998 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД Н.БАЯРТСАЙХАН**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Ө.ЭНХТҮВШИН**

***Засгийн газрын 2006 оны 115 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт***

## ХӨГЖМИЙН ТОМ ХЭЛБЭРИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ УЛСЫН САНД ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжмийн зохиолчдын сонгодог хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээл (цаашид "бүтээл" гэнэ)-ээс сонгон шалгаруулах, үнэлэх, улсын санд худалдан авах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Худалдан авсан хөгжмийн бүтээлүүдийн симфони, гоцлол хөгжим, дуунд зориулсан төгөлдөр хуурын хамсраа бүтээлийн дарамж (клавир), цөөхүүл болон их найрал, үндэсний их найрал хөгжимд зориулсан бичвэр (партитур)-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хадгална.

### Хоёр. Бүтээлд тавигдах шаардлага

2.1. Бүтээл нь хөгжмийн зохиолчийн сүүлийн 3 жилд туурвисан хөгжмийн жижиг хэлбэрийн бүтээлүүд болох дуу, дууны аяз, найруулга зэргээс бусад бүрэн хэмжээний бүтээл (хөгжмийн том хэлбэрийн бүтээл) байна.

2.2. Бүтээл нь жил бүр зохиогддог "Алтан намар" мэргэжлийн хөгжмийн наадамд шалгарсан, мэргэжлийн урлагийн байгууллагын тайзнаа тоглогдсон байна.

2.3. Зохиогч улсын санд худалдах бүтээлээ (клавир, партитурын гар бичмэл буюу эх хувь) дараахь материалын хамт Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд ирүүлнэ:

-Улсын санд бүтээлээ худалдах тухай хүсэлт, өргөдөл;

-Бүтээлийн тухай товч танилцуулга, бүтээлийн үнэлгээ;

-Уг бүтээлийн талаар гарсан 2-оос доошгүй судалгаа, шүүмж болон сонин хэвлэлд гарсан нийтлэл;

-Мэргэжлийн урлагийн байгууллагын тайзнаа тоглогдсон тухай тодорхойлолт;

-Тоглолтын үеэр сонирхогчийн болон мэргэжлийн түвшинд хийгдсэн аудио, видео бичлэг.

### Гурав. Бүтээлийг худалдан авах

3.1. Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу зохиогчтой нь тохиролцсоны үндсэн дээр хөгжмийн том хэлбэрийн бүтээлийг улсын санд худалдан авна.

3.2. Бүтээлийг шинжлэн үзэж, зохиогчийн үнэлсэн үнэлгээнд тулгуурлан зөвшилцөх замаар улсын санд худалдан авах эсэх дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "зөвлөл" гэнэ)-ийг тухай бүр соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилон ажиллуулна.

3.3. Зөвлөл нь 7-гоос доошгүй гишүүнтэй байх бөгөөд мэргэжлийн хөгжмийн онолч, судлаач, театрын найруулагч, удирдаач, мэргэжлийн урлагийн сургалтын байгууллага, соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдсэн байна.

3.4. Зөвлөлийн хурлыг жилд нэг удаа зохион байгуулна.

3.5. Зөвлөл нь 85-аас доошгүй хувийн ирцтэй хуралдаж, бүтээлийг улсын санд худалдан авах эсэх шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар гаргана.

3.6. Зөвлөлийн хурлаас тэмдэглэл гарах бөгөөд хурлын тэмдэглэлд зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Хурлаас гарсан тэмдэглэлийг үндэслэж соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэр гаргана.

3.7. Зөвлөлийн гишүүний бүтээлийг худалдаж авах тохиолдолд тухайн асуудлыг

хэлэлцэх, санал хураахад уг гишүүн нь оролцохгүй.

**Дөрөв. Бүтээлийг худалдан авах хөрөнгө, түүний зарцуулалт**

4.1. Улсын санд худалдан авахаар сонгосон бүтээлийг тухайн жилд хуваарилсан хөрөнгөд багтаан улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Төсвөөс олгосон хөрөнгийн 15 хувийг бүтээлийг хувилах, сурталчлах, зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгоход зарцуулна.

4.3. Хөгжмийн бүтээл худалдан авах тухай соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр нь хөрөнгийг захиран зарцуулах үндэслэл болно.

4.4. Энэ журмын биелэлтэд соёлын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

**Тав. Бүтээлийн зохиогчийн эрх**

5.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүтээлээ худалдсан зохиогчтой бүтээлийн онцгой эрх шилжүүлэх тухай гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулна.

***Засгийн газрын 2006 оны 115 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт***

**ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ УЛСЫН САНД ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Орчин үеийн дүрслэх урлагийн шилдэг бүтээл (уран зураг, баримал, зураасан зураг, чимэг, чимэглэх урлаг, дизайн болон орчин үеийн урлагийн төрөл зүйл)-ийг сонгон шалгаруулах, үнэлэх, улсын санд худалдан авах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Худалдан авсан дүрслэх урлагийн шилдэг бүтээл (цаашид "бүтээл" гэнэ)-ийг Уран зургийн галерейн сан хөмрөгт бүртгэн хадгална.

**Хоёр. Бүтээлд тавигдах шаардлага**

2.1. Улсын санд худалдан авах дүрслэх урлагийн шилдэг бүтээл нь уран бүтээлчийн сүүлийн 3 жилд туурвисан бүтээл байна.

2.2. Бүтээл нь нийтийн хүртээл болсон, орчин үеийн дүрслэх урлагийн хөгжлийн ололт, чиг хандлага, үзэл баримтлалыг илэрхийлсэн, ур чадварын өндөр түвшинд болон материал,технологийн хувьд чанартай хийгдсэн, музей, галерейн сан хөмрөгт хадгалах, дэлгэн үзүүлэх боломжтой байвал зохино.

2.3. Бүтээл нь олон улсын үзэсгэлэнд шилэгдэн оролцсон болон шагнал хүртсэн бол гэрчлэх бичиг баримтыг хавсаргасан байна.

**Гурав. Бүтээлийг худалдан авах**

3.1. Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу зохиогчтой нь тохиролцсоны үндсэн дээр дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авна.

3.2. Бүтээлийг шинжлэн үзэж, зохиогчийн үнэлсэн үнэлгээнд тулгуурлан зөвшилцөх замаар улсын санд худалдан авах эсэх дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "зөвлөл" гэнэ)-ийг тухай бүр соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилон ажиллуулна. Зөвлөл нь бүтээлийг сонгон шалгаруулахдаа төрөөс дүрслэх урлагийг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг дэмжих зарчим баримтална.

3.3. Зөвлөл нь 7-гоос доошгүй гишүүнтэй байх бөгөөд мэргэжлийн уран бүтээлчид, урлаг судлаач, шүүмжлэгч, соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Монголын урчуудын эвлэлийн хороо, Уран зургийн галерейн төлөөлөлтэй байна.

3.4. Зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

3.5. Зөвлөл нь 85-аас доошгүй хувийн ирцтэй хуралдаж, бүтээлийг улсын санд худалдан авах эсэх шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар гаргана.

3.6. Зөвлөлийн хурлаас тэмдэглэл гарах бөгөөд хурлын тэмдэглэлд зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийг үндэслэж соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэр гаргана.

3.7. Зөвлөлийн гишүүний бүтээлийг худалдаж авах тохиолдолд тухайн асуудлыг хэлэлцэх, санал хураахад уг гишүүн нь оролцохгүй.

3.8. Бүтээлийг мэргэжлийн урлагийн байгууллагаас зохион байгуулсан үзэсгэлэн, олон улсын шилмэл бүтээлийн үзэсгэлэн болон уран бүтээлчдийн бие даасан үзэсгэлэнгээс сонгон шалгаруулна.

**Дөрөв. Бүтээлийг худалдан авах хөрөнгө, түүний зарцуулалт**

4.1. Улсын санд худалдан авахаар сонгосон бүтээлийг тухайн жилд хуваарилсан хөрөнгөд багтаан улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Төсвөөс олгосон хөрөнгийн 15 хувийг дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг сурталчлах, зөвлөлийн гишүүдийг урамшуулахад зарцуулна.

4.3. Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг худалдан авах тухай соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр нь хөрөнгийг захиран зарцуулах үндэслэл болно.

4.4. Дуудлагын худалдаагаар худалдаж байгаа дүрслэх урлагийн бүтээлийг улсын төсвийн хөрөнгөөр худалдан авахыг хориглоно.

4.5. Энэхүү журмын биелэлтэд санхүүгийн болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

**Тав. Бүтээлийн зохиогчийн эрх**

5.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүтээлээ худалдсан иргэнтэй бүтээлийг ашиглах онцгой эрх шилжүүлэх тухай гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр** **Дугаар 119** **Улаанбаатар хот**

**Барилгын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралтад даалгасугай:

а/барилгын нийтлэг мэргэжил тус бүрээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, тэдгээрийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, энэ чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг сургалтын бусад байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий барилгын мэргэжлийн сургалтын загвар төвүүдийг зохих журмын дагуу ажиллуулах;

б/барилгын салбарын мэргэжилтэй ажилтныг ажлын байраар хангах асуудлыг "40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран шийдвэрлэж байх.

2. Барилгын мэргэжлийн сургалтын загвар төвийн техник, тоног төхөөрөмж, дадлагын газрыг сайжруулахад шаардагдах зардал болон барилгын мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, энэ чиглэлээрх сурах бичиг, гарын авлага зохиох, хэвлэхэд шаардагдах 368.0 /гурван зуун жаран найман/ сая төгрөгийг гадаад, дотоодын зээл, тусламжийн хөрөнгө болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэд, Сангийн сайд Н.Баяртсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт нарт даалгасугай.

3. Барилгын салбарын мэргэжилтэй ажилтны хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 5 жил тутам хийх, мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд зориулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас барилгын салбарын нэг суралцагчид зарцуулах зардал, эрхийн бичгийн хэмжээг 2006 оноос нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд даалгасугай.

4. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт нарт үүрэг болгосугай:

а/барилгын мэргэжлийн сургалтын агуулга, сурах бичиг, гарын авлагыг шинэчлэн боловсруулж 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн сургалтад хэрэглэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

б/барилгын салбарын мэргэжилтэй ажилтан, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2006 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэх.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 120** **Улаанбаатар хот**

**Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 163 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Тэмдэглэлт өдрүүд"-ийн жагсаалтад дор дурдсан 50 дахь заалтыг нэмсүгэй:

"50. Стандарт, хэмжил зүйн ажилтны өдөр- 10 дугаар сарын 14"

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХСАЙХАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 123** **Улаанбаатар хот**

**Хамгаалалтын бүс тогтоох тухай**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар бүлгийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсийг 121967 га газар байхаар тогтоож, хамгаалалтын бүсийн хилийн цэгүүдийн солбицлыг хавсралт ёсоор батлалсугай.

2. Түүх, соёлын дурсгалт цогцолбор газрын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин, Өвөрхангай аймгийн Засаг дарга Б.Эрдэнэбилэгт, Архангай аймгийн Засаг дарга Ж.Хүрэлсүх нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Ө.ЭНХТҮВШИН**

***Засгийн газрын 2006 оны 123 дугаар тогтоолын хавсралт***

### ДЭЛХИЙН ӨВ-ОРХОНЫ ХӨНДИЙН СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЦЭГИЙН СОЛБИЦЛЫН ЖАГСААЛТ

| Цэг № | Байршил | | Тэгш өнцөгт солбицол | | Геодезийн солбицол | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | X | Y | B | L |
| 1 | L-48-14 | Архангай аймаг.Өгийнуур Хашаат сумдын хил. Хүрэн Чулуут уул 1533.7 | 5277950 | 18336825 | 47-36-52.4 | 102-49-46.2 |
| 2 | L-48-14 | Архангай аймаг. Хашаат сум Эмээл толгой | 5271240 | 18340850 | 47-33-19.0 | 102-53-07.6 |
| 3 | L-48-14 | Архангай аймаг. Хашаат сум Цайдам бригадын төв | 5265525 | 18338050 | 47-30-11.6 | 102.51.01.4 |
| 4 | L-48-14 | Архангай аймаг. Хашаат сум Их дэл уулын хөтөл | 5260150 | 18338250 | 47-27-17.8 | 102-51-18.0 |
| 5 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Хар толгой худгаас баруун хойш | 5245675 | 18345300 | 47-19-35.6 | 102-57-12.5 |
| 6 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Хэрэгтийн худгаас баруун урагш | 5239850 | 18343350 | 47-16-25.4 | 102-57-47.1 |
| 7 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Тариан талбайн захаас баруун урагш 1.2 км | 5237700 | 18339450 | 47-15-12.5 | 102-52-44.4 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5235000 | 18339021 | 47-13-44.7 | 102-52-27.5 |
| 9 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5231804 | 18338530 | 47-12-00.9 | 102-52-08.3 |
| 10 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5231730 | 18337625 | 47-11-57.7 | 102-51-25.5 |
| 11 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5231009 | 18337603 | 47-11-34.3 | 102-51-25.4 |
| 12 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5231000 | 18337206 | 47-11-33.7 | 102-51-06.5 |
| 13 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5231403 | 18335582 | 47-11-45.3 | 102-49-45.9 |
| 14 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5233136 | 18335979 | 47-12-41.7 | 102-50-05.5 |
| 15 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5233296 | 18336190 | 47-12-47.1 | 102-50-15.3 |
| 16 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5233432 | 18336056 | 47-12-51.3 | 102-50-08.7 |
| 17 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5233983 | 18336183 | 47-13-09.3 | 102-50-14.0 |
| 18 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5234325 | 18335625 | 47-13-19.8 | 102-49-47.1 |
| 19 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5233125 | 18333900 | 47-12-39.5 | 102-48-26.8 |
| 20 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5231575 | 18333575 | 47-11-49.0 | 102-48-13.4 |
| 21 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5231000 | 18334000 | 47-11-30.8 | 102-48-34.3 |
| 22 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5230175 | 18332625 | 47-11-02.8 | 102-47-30.2 |
| 23 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5229875 | 18332400 | 47-10-52.9 | 102-47-19.9 |
| 24 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5229575 | 18332800 | 47-10-43.6 | 102-47-39.3 |
| 25 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5229450 | 18333775 | 47-10-40.4 | 102-48-25.7 |
| 26 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5229800 | 18335825 | 47-10-53.6 | 102-50-02.6 |
| 27 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5229550 | 18336100 | 47-10-45.8 | 102-50-15.9 |
| 28 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум | 5230475 | 18337900 | 47-11-17.3 | 102-51-40.2 |
| 29 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Мэлхий толгойгоос зүүн тийш Жижиг толгой | 5229350 | 18338350 | 47-10-41.3 | 102-52-03.0 |
| 30 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Хүрээгийн харын өндөрлөг | 5228150 | 18338900 | 47-10-03.0 | 102-52-30.6 |
| 31 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Цагдуулт уул 1955.9 | 5219500 | 18334350 | 47-05-19.0 | 102.49.06.2 |
| 32 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Хамар уул 1812.4 | 5219500 | 18334350 | 47-05-19.0 | 102-49-06.2 |
| 33 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум Бага моилт уул 1855.1 | 5212300 | 18327300 | 47-01-19.5 | 102-43-42.1 |
| 34 | L-48-38 | Өвөрхангай аймаг. Хужирт сум Бэрх уул 1853.0 | 5206300 | 18319300 | 47-57-57.7 | 102-37-32.2 |
| 35 | L-48-38 | Өвөрхангай аймаг. Хужирт сум Оорцог Уул 1873.9 | 5199500 | 18311300 | 46-54-09.7 | 102-31-24.3 |
| 36 | L-48-37 | Өвөрхангай аймаг. Хужирт сум 1787.4 | 5197750 | 18308250 | 46-53-099 | 102-29-03.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 37 | L-48-37 | Өвөрхангай аймаг. Хужирт сум Мухдаг уул (Салхит уул) | 5195370 | 19305650 | 46-51-50.2 | 102-27-03.9 |
| 38 | L-48-37 | Өвөрхангай аймаг.Бат-Өлзийт сум Цаган өвийн голын уулзвар | 519400 | 18293300 | 46-50-52.5 | 102-17-23.7 |
| 39 | L-48-37 | Өвөрхангай аймаг.Бат-Өлзийт сум Аргалант уул 2325.3 | 5199100 | 18280950 | 46-53-23.3 | 102-07-32.7 |
| 40 | L-48-37 | Өвөрхангай аймаг.Бат-Өлзийт сум Ар гуя уул 1981.9 | 5210150 | 18286650 | 46-59-27.3 | 102-11-43.0 |
| 41 | L-48-25 | Өвөрхангай аймаг.Бат-Өлзийт сум Хүрэн толгойн уул 2325.3 | 5212120 | 18288000 | 47-00-32.6 | 102-12-43.5 |
| 42 | L-48-25 | Архангай аймаг. Хотонт сум. Эмгэнт уул 2227.7 | 5215150 | 18286500 | 47-02-08.9 | 102-11-27.4 |
| 43 | L-48-25 | Архангай аймаг. Хотонт сум Өндөр овоот 2312.0 | 5215400 | 18294250 | 47-02-25.8 | 102-17-33.7 |
| 44 | L-48-37 | Архангай аймаг. Хотонт сум Шуутийн гозгор 1972.0 | 5207500 | 18303800 | 46-58-20.7 | 102-25-17.9. |
| 45 | L-48-38 | Архангай аймаг. Хотонт сум 1892.0 | 5208200 | 18311100 | 46-58-50.9 | 102-31-01.9 |
| 46 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хужирт сум. Голын ханан уул 1956.0 | 5211000 | 18316850 | 47-00-27.4 | 102-35-29.6 |
| 47 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хужирт сум Баруун нарт уул 2050.0 | 5215180 | 18316600 | 47-02-42.4 | 102-35-11.7 |
| 48 | L-48-26 | Өвөрхангай, Архангай аймгийн хилийн заат дээр Өндөрсант уул 2364.6. | 5218950 | 18310950 | 47-04-38.6 | 102-30-38.6 |
| 49 | L-48-26 | Өвөрхангай, Архангай аймгийн хилийн заат. Дунд Хутаг уул 2321.1 | 5222650 | 18312800 | 47-06-40.2 | 102-32-00.7 |
| 50 | L-48-26 | Өвөрхангай, Архангай аймгийн хилийн заат.Баянзүрх уул 2252.4 | 5225000 | 18318600 | 47-08-02.0 | 102-36-32.1 |
| 51 | L-48-26 | Өвөрхангай, Архангай аймгийн хилийн заат.Нуурын гозгорын баруун даваа | 5227200 | 18320100 | 47-09-14.7 | 102-37-40.1 |
| 52 | L-48-26 | Өвөрхангай, Архангай аймгийн хилийн заат Нуурын гозгор уул 2070.3 | 5229700 | 18320350 | 47-10-35.8 | 102-37-48.3 |
| 53 | L-48-26 | Өвөрхангай, Архангай аймгийн хилийн заат.Будлондон-Өвөр цагаан гүүт голын уулзвар | 5234600 | 18323200 | 47-13-17.1 | 102-39-56.6 |
| 54 | L-48-26 | Өвөрхангай, Архангай аймгийн хилийн заат. Их, Бага Арцатын голын уулзвар | 5234550 | 18328230 | 47-13-20.3 | 102-43-55.6 |
| 55 | L-48-26 | Өвөрхангай аймаг. Хархорин сум. Бага Саруул уул 1861.5 | 5237700 | 18327550 | 47-15-01.6 | 102-43-18.9 |
| 56 | L-48-26 | Архангай аймаг. Хотонт сум. 1755.1 | 5239290 | 18323500 | 47-15-49.2 | 102-40-04.2 |
| 57 | L-48-26 | Архангай аймаг. Хотонт сум. | 5247115 | 18321124 | 47-20-00.0 | 102-38-00.0 |
| 58 | L-48-14 | Архангай аймаг. Хотонт сум. 1489.5 | 5252600 | 18312350 | 47-22-49.2 | 102-31-22.7 |
| 59 | L-48-14 | Архангай аймаг. Хотонт сум. Цолмон толгой 1547.3 | 5259000 | 18316990 | 47-26-20.4 | 102-34-25.6 |
| 60 | L-48-14 | Архангай аймаг. Өгийнуур, Хотонт сумдын хилийн заат | 5271700 | 18311850 | 47-33-05.9 | 102-30-01.1 |
| 61 | L-48-14 | Архангай аймаг. Өгийнуур, Хотонт сумдын хилийн заат | 5271700 | 18314130 | 47-33-39.1 | 102-31-48.6 |
| 62 | L-48-14 | Архангай аймаг. Өгийнуур, Хотонт сумдын хилийн уулзвар 1373.5 | 5274350 | 18325100 | 47-34-45.0 | 102-40-30.4 |
| 63 | L-48-14 | Архангай аймаг. Өгийнуур, Хотонт сумдын хилийн заат 1415.1 | 5275150 | 18332650 | 47-35-18.1 | 102-46-30.3 |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эрхлэл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 2.5

☎ 329487